



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал  
/шинэчилсэн найруулга/-ыг  
батлах тухай

Авлигын эсрэг хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.6, Улсын Их хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолоор баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.1.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал" /шинэчилсэн найруулга/-ыг хавсралтаар баталсугай.

2. Авлигын эрсдэлийн үнэлгээг тухай бүр удирдан зохион байгуулж, дүнг танилцуулж байхыг Судалгаа, шинжилгээний алба /Ахлах комиссар Ц.Шинэбаяр/, үнэлгээнд үндэслэн авлигын эрсдлээс хамгаалах, эрсдлийг бууруулах арга хэмжээг зохион байгуулж, дүнг хагас жил тутамд танилцуулж байхыг Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс /Эрхэлсэн комиссар Т.Баярхүү/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын хэлтэс /Эрхэлсэн комиссар З.Баасанням/-т даалгасугай.


4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал"-ыг батлах тухай А/185 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮН КОМИССАР



Х.ЭНХЖАРГАЛ

Авлигатай тэмцэх газрын даргын  
2019 оны 05 дугаар сарын 7-ны  
өдрийн 4/10 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт



---

**ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ АВЛИГЫН  
ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

---

## Гарчиг

<b>ТАНИЛЦУУЛГА.....</b>	<b>2</b>
<b>ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ.....</b>	<b>3</b>
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ .....	3
1. Аргачлалын зорилт.....	3
2. Эрх зүйн үндэслэл .....	3
3. Нэр томьёны ойлголт.....	3
4. Авлигын эрсдэлийн үнэлгээний зорилго .....	3
5. Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ.....	3
6. Эрсдэлийн үнэлгээний хэлбэр.....	4
7. Мэдээлэл цуглуулах арга.....	4
8. Мэдээллийн эх үүсвэр .....	4
9. Үнэлгээний үе шат .....	4
10. Үнэлгээний явцад анхаарах асуудлууд .....	5
<b>ХОЁР. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ.....</b>	<b>5</b>
1. Баг бүрдүүлэх.....	5
2. Эрсдэлийн үнэлгээний төлөвлөгөө.....	5
3. Эрсдэлийг тодорхойлох.....	5
4. Тодорхойлсон эрсдэлийн түвшнийг үнэлэх.....	5
5. Зураглал хийх .....	6
6. Эрсдэлийн нөлөө .....	6
7. Эрсдэлийн магадлал.....	6
8. Үнэлгээний хуудас.....	6
9. Эрсдэлийн нөлөө бууруулах, арилгах зөвлөмж боловсруулах .....	6
10. Зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.....	7
<b>Ашигласан материал .....</b>	<b>14</b>

## ТАНИЛЦУУЛГА

---

Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-т "бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах" үүргийг авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд төрийн байгууллага бүрт оногдуулсан байдаг бөгөөд энэ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгахад чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэхийн тулд Авлигын эрсдэлийн үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатай байна.

Мөн УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.1.1.5-д Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлэх хүрээнд "авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг баталж, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж хэвшүүлэх"-ээр заасан.

Авлигын эрсдэлийн үнэлгээг зохион байгуулснаар тухайн байгууллагын ямар үйл ажиллагаа, эсхүл аль нэгжид авлигын эрсдэл байгааг тодорхойлох, улмаар авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөн, зохион байгуулахдаа мэдээлэлд суурилсан шийдвэр гаргах боломж бүрдэх юм. Эдгээр шаардлагыг хангах зорилгоор төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлалыг боловсруулсан бөгөөд төрийн байгууллага, эсхүл түүний салбар, нэгж өөрийн онцлогтоо нийцүүлэн өөрчлөн ашиглах боломжтой юм.

Энэхүү аргачлал нь авлигын эрсдэлийн үнэлгээний таван үе шат (нөхцөл байдлаа тодорхойлох, төлөвлөгөө боловсруулах; эрсдэлээ үнэлж тодорхойлох; эрсдэлийн түвшинг үнэлэх; зураглал хийх; эрсдэлийн нөлөөг бууруулах, арилгах зөвлөмж боловсруулах; зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих) болон эрсдэлийн үнэлгээнд ашиглаж болох загвар асуулгыг багтаасан.

# ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА ДАХЬ АВЛИГЫН ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1. Аргачлалын зорилт

1.1. Төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал (цаашид "Аргачлал" гэх) - ийн зорилт нь төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийг үнэлэх үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах талаар арга зүйн тусламж дэмжлэг үзүүлэхэд оршино.

### 2. Эрх зүйн үндэслэл

2.1. Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12, 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолоор батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн 4.1.1.5 дах заалт нь тус тус төрийн байгууллагад авлигын эрсдэлийг үнэлэх, уг үнэлгээнд шаардлагатай аргачлалыг боловсруулж батлах үндэслэл болно.

### 3. Нэр томъёоны ойлголт

3.1. Аргачлалд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "авлига" гэж Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад заасныг;

3.1.2. "ашиг сонирхлын зөрчил" гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дах заалтад заасныг.

### 4. Авлигын эрсдэлийн үнэлгээний зорилго

4.1. Авлигын эрсдэлийн үнэлгээ нь дараах зорилгыг агуулна:

4.1.1. Төрийн байгууллага дахь авлига, ашиг сонирхлын зөрчилтэй үйл ажиллагаа, түүний хэлбэр, цар хүрээ, шалтгаан нөхцөлийг тодорхойлох;

4.1.2. Авлигын эрсдэлийн түвшинг тогтоох;

4.1.3. Эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг чиглүүлэх;

4.1.4. Эрсдэлийг бууруулах, арилгахад чиглэсэн үйл ажиллагааг тодорхойлох;

4.1.5. Ижил төстэй үйл ажиллагааны эрсдэлийг харьцуулах;

4.1.6. Шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг мэдээллээр хангах.

### 5. Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ

5.1. Эрсдэлийн үнэлгээнд байгууллагын бүхий л үйл ажиллагаа, чиглэлийг хамруулна.

5.2. Эрсдэлийн үнэлгээг байгууллагын үйл ажиллагааны дараах чиглэлээр тусгайлан зохион байгуулж болно:

5.2.1. Чиг үүрэг, бүтэц;

5.2.2. Төсөв, санхүү;

5.2.3. Шийдвэр гаргах явц;

5.2.4. Ил тод байдал;

5.2.5. Хариуцлага тооцох механизм;

5.2.6. Мэдээллийн хүртээмж;

5.2.7. Бүртгэл;

5.2.8. Хүний нөөцийн удирдлага, зохион байгуулалт;

5.2.9. Ёс зүй, шударга байдлын түвшин;

- 5.2.10. Өргөдөл, гомдол, мэдээлэл;
- 5.2.11. Авлигын эсрэг бодлого;
- 5.2.12. Сургалт, давтан сургалт;
- 5.2.13. Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл;
- 5.2.14. Бусад.

5.3. Эрсдэлийн үнэлгээний хамрах хүрээ нь үнэлгээ хийж буй байгууллагын цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, чадавх, нөөц боломжоос хамааран харилцан адилгүй байж болно.

5.4. Үнэлгээнд байгууллагыг бүхэлд нь эсхүл салбар, хэлтэс, алба, нэгжийг хамруулж болно.

#### **6. Эрсдэлийн үнэлгээний хэлбэр**

6.1. Эрсдэлийн үнэлгээ нь дараах хэлбэртэй байна.

6.1.1. Өөрийн үнэлгээ. Үнэлгээнд хамрагдаж байгаа байгууллагын албан тушаалтнуудаас бүрдсэн баг үнэлгээг хариуцан гүйцэтгэвэл өөрийн үнэлгээ болно.

6.1.2. Хөндлөнгийн үнэлгээ. Үнэлгээнд хамрагдаж байгаа байгууллагад ажилладаггүй хүмүүсээс бүрдсэн баг үнэлгээг хариуцан гүйцэтгэвэл хөндлөнгийн үнэлгээ болно.

6.1.3. Хосолсон хэлбэр. Үнэлгээнд хамрагдаж байгаа байгууллагын албан тушаалтан болон гаднаас бүрдсэн баг үнэлгээг хийвэл хосолсон хэлбэр гэж үзнэ.

#### **7. Мэдээлэл цуглуулах арга**

7.1. Эрсдэлийн үнэлгээнд дараах аргуудыг ашиглана.

7.1.1. Тоон судалгаа. Үүнд асуулгын болон бусад арга.

7.1.2. Чанарын судалгааны арга. Үүнд: ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага, цаасан болон цахим мэдээлэлд дүн шинжилгээ хийх, бусад арга.

7.1.3. Үнэлгээний цар хүрээнээс хамаарч эдгээр аргыг дангаар болон хослуулан хэрэглэнэ.

#### **8. Мэдээллийн эх үүсвэр**

8.1. Мэдээлэл цуглуулахдаа дараах эх үүсвэрийг ашиглаж болно:

8.1.1. Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа олон улсын гэрээ, хууль, эрх зүйн акт;

8.1.2. Дотоод дүрэм, журам, стандарт, аргачлал, зөвлөмж;

8.1.3. Байгууллагын цахим хуудас болон бусад сайт;

8.1.4. Аудитын тайлан;

8.1.5. Дотоод аудит, хяналт, шалгалтын ажлын тайлан, үр дүнг харуулсан бусад материал;

8.1.6. Статистикийн мэдээлэл;

8.1.7. Судалгаа, дүн шинжилгээ, тэдгээрийн тайлан, бусад материал;

8.1.8. Тухайн байгууллага болон байгууллагад ажилтан, албан тушаалтантай холбоотой гэмт хэрэг гарсан шүүхийн шийдвэр, бусад материал;

8.1.9. Өргөдөл, гомдол, мэдээлэл (нэрээ нууцалсан болон нууцлаагүй);

8.1.10. Иргэний нийгмийн байгууллагуудын тайлан, мэдээлэл;

8.1.11. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд гарсан мэдээлэл;

8.1.12. Нийгмийн сүлжээний мэдээлэл;

8.1.13. Бусад мэдээлэл.

#### **9. Үнэлгээний үе шат**

9.1. Үнэлгээ нь дараах үе шаттай байна:

- 9.1.1. Үнэлгээний баг бүрдүүлэх;
- 9.1.2. Үнэлгээний төлөвлөгөө боловсруулах;
- 9.1.3. Эрсдэл тодорхойлох, зураглал хийх;
- 9.1.4. Эрсдэлийг бууруулах, арилгах үйл ажиллагааг тодорхойлж төлөвлөх;
- 9.1.5. Үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.

#### **10. Үнэлгээний явцад анхаарах асуудлууд**

- 10.1. Үнэлгээний явцад дараах асуудлуудад анхаарах нь зүйтэй. Үүнд:
  - 10.1.1. Тухайн байгууллага, салбарын үйл ажиллагааг зохион байгуулж байгаа хууль тогтоомж болон Авлигын эсрэг хуулийн уялдаа холбоо;
  - 10.1.2. Тухайн салбарын үйл ажиллагааны онцлог;
  - 10.1.3. Тухайн салбар, байгууллагын талаар олон нийтийн дунд тогтсон ойлголт, хандлага, төсөөлөл (ээрэг болон сөрөг);
  - 10.1.4. Тухайн салбар, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, албан хаагчдын тоо.

### **ХОЁР. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ**

#### **1. Баг бүрдүүлэх**

- 1.1. Эрсдэлийн үнэлгээг гардан гүйцэтгэх багт дараах шаардлагыг хангасан хүмүүс ажиллах шаардлагатай. Үүнд:
  - 1.1.1. Төрийн албаны талаар нийтлэг, тухайн салбар, байгууллагын талаар тодорхой ойлголт, мэдлэгтэй;
  - 1.1.2. Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харилцааны болон бичиж боловсруулах ур чадвартай;
  - 1.1.3. Судалгаа, дүн шинжилгээ, мониторинг, хяналт шалгалт, аудитын ажлын туршлагатай;

1.2 Багийн гишүүдийн тоо нь нөхцөл байдлаас хамаарч өөр өөр байх боломжтой.

#### **2. Эрсдэлийн үнэлгээний төлөвлөгөө**

2.1. Төлөвлөгөөнд дараах асуудлуудыг хамруулна:

- 2.1.1. Хамрах хүрээ;
- 2.1.2. Хийгдэх үйл ажиллагаа;
- 2.1.3. Хариуцах эзэн;
- 2.1.4. Хамтран оролцогч;
- 2.1.5. Хугацаа;
- 2.1.6. Төсөв;
- 2.1.7. Гарах үр дүн.

#### **3. Эрсдэлийг тодорхойлох**

3.1. Эрсдэлийг тодорхойлоход дараах мэдээллийг ашиглана:

- 3.1.1. Аргачлалын 8.1-т заасан эх үүсвэрээс цуглуулсан мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ;
- 3.1.2. Шинжээчдийн үнэлгээ;
- 3.1.3. Албан хаагчдын дунд зохион байгуулсан судалгааны үр дүн.

*(Судалгааны загвар асуулгыг 1 дүгээр хавсралтаар харуулав)*

#### **4. Тодорхойлсон эрсдэлийн түвшнийг үнэлэх**

4.1. Эрсдэлийг үнэлэхдээ эрсдэлийн төрөл ба түвшингийн үзүүлэлтийг тодорхойлж, харьцуулан шинжлэнэ.

4.2. Эрсдэлийн түвшинг үнэлэхдээ чанарын болон тоон аргаар цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийнэ.

4.3. Чанарын үнэлгээ нь үр дагавар, магадлалын хослолоор илэрхийлэгдэх "их", "дунд", "бага" гэсэн тодорхой үзүүлэлтээр эрсдэлийн түвшин, магадлал, үр дагаврыг тодорхойлж, чанарын шалгуураар эрсдэлийн түвшинг үнэлнэ.

4.4. Тоон шинжилгээний аргаар үр дагавар ба түүний магадлалын бодит хэмжээг тооцоолох ба нөхцөл байдлыг тодорхойлох үед тогтоосон тусгай нэгжээр эрсдэлийн түвшингийн хэмжээг гаргана.

#### **5. Зураглал хийх**

5.1. Зураглалын дараах үндсэн үзүүлэлтүүд байна:

- 5.1.1. Эрсдэлийн нөлөөлөл буюу үр дагавар;
- 5.1.2. Эрсдэлийн магадлал буюу давтамж;
- 5.1.3. Эрсдэлийн цар хүрээ;
- 5.1.4. Эрсдэлийн нуугдмал байдал;
- 5.1.5. Үргэлжилж байгаа хугацаа;
- 5.1.6. Бусад.

5.2. Эрсдэлийн зураглалд нэг төрлийн үйл ажиллагааг хамааруулж болохоос гадна олон төрлийн үйл ажиллагаа жишээлбэл, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн үйл ажиллагааг хамруулан харьцуулж болно.

*(Эрсдэлийн зураглалын жишээг 2 дугаар хавсралтаар харуулав)*

#### **6. Эрсдэлийн нөлөө**

6.1. Нөлөөллийг тодорхойлоход харгалзан үзэх хүчин зүйлс:

6.1.1. Тухайн байгууллагад болон бусад бусад ижил төстэй байгууллагад гарсан авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчил, ашиг сонирхлын зөрчлийн улмаас иргэдийн эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, аюулгүй байдал, амьдрах орчин, хүрээлэн байгаа орчин, байгаль орчинд үзүүлсэн нөлөө;

6.1.2. Байгууллага, салбарын үйл ажиллагаанд олон нийтийн итгэх итгэлд орсон өөрчлөлт;

6.1.3. Эдийн засгийн, санхүү, хөрөнгө оруулалтын алдагдал;

6.1.4. Бусад.

#### **7. Эрсдэлийн магадлал**

7.1. Эрсдэлийн магадлалыг тооцоход харгалзан үзэх хүчин зүйлс:

7.1.1. Тухайн хэрэг, зөрчилтэй холбогдож болох бусад үйл ажиллагаа;

7.1.2. Тухайн байгууллагад өнгөрсөн хугацаанд үйлдэгдэж байсан авлигын хэрэг, зөрчлийн давтамж.

7.1.3. Бусад.

#### **8. Үнэлгээний хуудас**

8.1. Эрсдэлийн зураглал хийхэд үнэлгээний хуудсыг ашиглаж болно.

*(Үнэлгээний хуудасны загварыг 3 дугаар хавсралтаар харуулав)*

#### **9. Эрсдэлийн нөлөө бууруулах, арилгах зөвлөмж боловсруулах**

9.1. Энэ үе шатанд өмнөх үе шатуудад тодорхойлогдсон эрсдэлийг бууруулах, арилгах зөвлөмжийг боловсруулна. Зөвлөмж нь дараахь шаардлагыг хангасан байна:

9.1.1. Хууль тогтоомжид нийцсэн байх. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс



урьдчилан сэргийлэх тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Шилэн дансны хууль, болон УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралт "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр" зэрэг хууль тогтоомжид нийцсэн байх;

9.1.2 Хэрэгжих боломжтой байх;

9.1.3. Тодорхой байх.

**10. Зөвлөмжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих**

10.1. Эрсдэлийн үнэлгээний хүрээнд зөвлөмж боловсруулж хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий албан тушаалтанд хүргэснээс хойш тухайн менежер байгууллагын стратеги, үйл ажиллагаатайгаа уялдуулан зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулна.

10.2. Уг төлөвлөгөөнд зөвлөмжийг хэрэгжүүлэх хугацаа, хариуцан хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгаж өгөх бөгөөд загварын дагуу боловсруулж болно. (Хавсралт №4)

10.3. Байгууллагын дотоод болон гадаад орчны өөрчлөлттэй холбогдуулан зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнд байгууллагын удирдлагын зүгээс тогтмол хяналт тавьж, авлигын эрсдэлийг бий болгох шинэ хүчин зүйл бий болж байгаа эсэхэд давтамжтай үнэлгээ өгч байх шаардлагатай.

---oO---

**ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ЗАГВАР АСУУЛГА (жишээ)**

Дараахь асуулгыг авлигын эрсдэлийг тодорхойлоход ашиглах бөгөөд уг асуулгыг үнэлгээний баг, эсхүл алба хаагчид болон бусад мэдээллээс тодорхойлох бөгөөд асуултын хариултыг 1-ээс 5 баллаар үнэлүүлэх нь зохимжтой байдаг. Хэрэв 5 бол сөрөг, эрсдэл их гэж үзнэ.

<p><b>А. Байгууллагын чиг үүрэг, бүтэц</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Танай байгууллагын үйл ажиллагааны аль хэсэг, эсхүл аль албан тушаал авлигын эрсдэлтэй вэ?</li> <li>2. Танай байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт хийдэг үү?</li> <li>3. Байгууллагын авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар алба хаагчдад, эсхүл үйлчлүүлэгч, олон нийтэд зөвлөмж, мэдээлэл хүргэдэг үү?</li> <li>4. Танай байгууллагын аль үйл ажиллагаанд албан тушаалтан дангаараа шийдвэр гаргадаг вэ?</li> <li>5. Танай байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий алба хаагчид сонирхлын зөрчлөөс ангид байж чаддаг уу?</li> <li>6. Албан үүргээ гүйцэтгэж буй алба хаагчдын дунд ажлын байрны тодорхойлолт дахь шалгуурыг хэр хангах вэ?</li> <li>7. Удирдах албан тушаалтнууд албан үүргээ гүйцэтгэж буй алба хаагчдын үйл ажиллагааны шат бүрт хяналт тавьж чаддаг уу?</li> <li>8. Үйл ажиллагаандаа ашиглаж буй дүрэм, журмын талаарх мэдээлэл ил тод байдаг уу?</li> </ol>
<p><b>Б. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээлэл ил тод байж чаддаг уу?</li> <li>2. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулдаг уу?</li> <li>3. Шууд худалдан авалт болон харьцуулалтын аргаар хэдэн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бэ? Уг худалдан авах ажиллагааны дүн, байгууллагын нийт худалдан авах ажиллагааны төсөвт хэдэн хувийг эзэлж байна вэ?</li> <li>4. Худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдэд нэр бүхий цөөн хүн ордог уу?, Үнэлгээний хороонд орохдоо мэдэгдэл тайлбар гаргадаг уу?</li> <li>5. Үйлчилгээ авсан иргэн, аж ахуйн нэгж байгууллага, харилцагчдаас төлбөр, хураамж, торгууль, шийтгэлийн орлого олдог уу? Эдгээр орлогын бүртгэл, банкинд байршуулах, аудит хийх, зарцуулахтай үйл ажиллагааг хэр зохицуулсан байдаг бэ?</li> <li>6. Тухайн онд хэдэн худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бэ? Түүнээс хэд нь амжилттай зохион байгуулагдсан бэ?</li> </ol>
<p><b>В. Хүний нөөцийн удирдлага</b></p> <ol style="list-style-type: none"> <li>1. Хүний нөөцийн талаарх мэдээлэл ил тод байдаг уу?</li> <li>2. Ажлаас халагдсан алба хаагчдын тоо хэд вэ?</li> <li>3. Ажлаас халагдсан алба хаагчдад хэдий хэмжээний нөхөн олговор, тусламж олгосон вэ?</li> <li>4. Шинэ алба хаагчдаа шударга ёсны талаар хичээл, сургалтад хамруулдаг уу?</li> <li>5. Сонирхлын зөрчлийн талаар алба хаагчдаа сургалт авдаг уу?</li> <li>6. ХАСУМ-ээ хянуулаагүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй алба хаагчийг томилсон эсэх?</li> <li>7. Алба хаагчид авч буй цалин, урамшууллынхаа хэмжээний талаар сэтгэл ханамж ямар түвшинд байдаг вэ?</li> </ol>

8. Тушаал дэвших, шагнал урамшил олгох үйл ажиллагаа хэрхэн зохион байгуулагддаг вэ?
9. Шинээр ажил албан тушаалд томилогдон ороход улс төрийн нөлөөллөөс хэр ангид байдаг вэ? Мэдлэг туршлага, ур чадварт суурилсан Мерит зарчмыг баримталж чаддаг уу?

#### **Г. Үйл ажиллагаа, шийдвэр гаргах үйл явц**

1. Танай байгууллага тусгай зөвшөөрөл олгодог уу?
2. Танай байгууллага иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг, санхүүжилт олгодог уу?
3. Олон нийтээс ямар нэгэн төлбөр хураамж авдаг уу?
4. Дээрх тусгай зөвшөөрөл, санхүүгийн дэмжлэг, төлбөр хураамжийн талаарх зохицуулалтын дүрэм, журам нь тодорхой байдаг уу?
5. Алба хаагчид албан үүрэгтэй холбоотойгоор харилцагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай удаа дараа нүүр тулж харилцах тохиолдол хэр их байдаг вэ?
6. Албан хаагчид албан үүрэгтэй холбоотой дангаараа шийдвэр гаргадаг уу? Хамтын шийдвэр гаргадаг уу? Эдгээр шийдвэрийн бүртгэл байдаг уу?

#### **Д. Ил тод байдал**

1. Хууль, тогтоомжийн дагуу ил тод байх ёстой мэдээлэл хангалттай ил тод байж чаддаг уу?
2. Ил тод байгаа мэдээлэл иргэд, олон нийтэд ойлгомж, хэрэглэхэд хялбар байж чаддаг уу?
3. Сүүлийн нэг жилийн хугацаанд иргэд, аж ахуйн нэгжээс мэдээлэл хүссэн хүсэлт, өргөдөл хүлээн авсан вэ?

#### **Е. Ёс зүйн болон шударга ёсны тогтолцоо**

1. Танай байгууллага өөрийн ёс зүйн дүрэмтэй юу?
2. Албан хаагчид ёс зүйн дүрмийн талаар сургалт авдаг уу?
3. Албан хаагчид ёс зүйн дүрмээ сайн мэдэх үү?
4. Сонирхлын зөрчилтэй тулгарсан үед ямар арга хэмжээ авах талаар алба хаагчид мэдэх үү?

#### **Ё. Хариуцлагын механизм**

1. Албан хаагчид үйл ажиллагаа, шийдвэрийнхээ талаар удирдах албан тушаалтандаа танилцуулах тухай бүр, тогтмол танилцуулдаг уу?
2. Дотоод ханалт, шалгалтын нэгж байдаг уу?
3. Сүүлийн нэг жилийн хугацаанд хэдэн удаа дотоод хяналт, шалтгалт зохион байгуулсан бэ?
4. Сүүлийн нэг жилийн хугацаанд дотоод хяналт, шалгалтын нэгжийн үйл ажиллагааны ололт юу байв?
5. Танай байгууллага гадаад буюу хөндлөнгийн хяналт, аудитыг хэр давтамжтай хийлгэдэг вэ?
6. Сүүлийн нэг жилийн хугацаанд дахь хөндлөнгийн хяналт, аудитын шалгалтын чухал дүгнэлт, үр дүн юу байв?

#### **Ж. Гомдлыг шийдвэрлэх, шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоо**

1. Танай байгууллага, албан хаагчдад гомдол гаргах журам тодорхой байдаг уу?
2. Гомдол, мэдээлэл өгсөн этгээдийн нууцлалыг хэр хангадаг вэ?
3. Нэрээ нууцалсан гомдол мэдээллийг хүлээн авах боломжийг бүрдүүлсэн байдаг уу?
4. Сүүлийн нэг жилийн хугацаанд хэдэн гомдол мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэсэн бэ?

5. Шүгэл үлээгчийг хамгаалах, эсхүл урамшуулах тогтолцоог дотоод журмаараа шийдвэрлэсэн үү?

### 3. Шийтгэл оногдуулах механизм

1. Сүүлийн нэг жилийн хугацаанд ёс зүйн дүрэм болон ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой асуудлаар хэдэн албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн бэ?
2. Ямар төрлийн хариуцлага хүлээлгэсэн бэ?
3. Алба хаагчдад хариуцлага тооцсон шийдвэрийг эсэргүүцэн хэдэн хувьд нь харьяа дээд шатны байгууллага болон шүүхэд гомдол гаргасан бэ?
4. Дотоод хяналт, аудитын нэгжээр дамжуулан илрүүлсэн авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллийг хууль хяналтын байгууллагад шилжүүлдэг үү? алдаа дутагдалд хариуцлага хүлээлгэдэг үү?

### И. Эрсдэл бүхий үйл ажиллагаа, чиг үүрэг

1. Танай байгууллагын аль үйл ажиллагаа, нэгж авлигад өртөх эрсдэлтэй бэ?
2. Авлигын эрсдэл бүхий үйл ажиллагаа, нэгжийн талаар эрсдэлийн шинжилгээ хийсэн үү?
3. Авлигын эрсдэлийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны төлөвлөгөө байдаг уу?

### Й. Авлигын эсрэг бодлого

1. Танай байгууллагад авлигатай тэмцэх бодлого, төлөвлөгөөтэй юу?
2. Танай байгууллагын стратеги нь авлигатай тэмцэх бодлоготойгоо уялдаатай байдаг уу?
3. Танай байгууллагын авлигатай тэмцэх бодлого, хөтөлбөрийн зорилго нь хүрч болохуйц тодорхой томъёологдсон байдаг уу?
4. Танай байгууллагын авлигатай тэмцэх бодлого, хөтөлбөр үйлчлүүлэгч буюу олон нийтэд ил тод байдаг уу?

### К. Удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл

1. Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд зориулан шаардлагатай хөрөнгийг төлөвлөн зарцуулдаг уу?
2. Байгууллага дахь авлигатай тэмцэх үйл ажиллагааны хэрэгжилт болон түүний үр дүнтэй байдалд байгууллагын удирдлага хяналт тавьдаг уу?
3. Танай байгууллагын удирдлага байгууллага дахь авлигын эсрэг соёлыг дэмждэг үү?
4. Танай байгууллагын удирдлага шүгэл үлээх механизмыг дэмждэг үү?
5. Танай байгууллагын удирдах албан тушаалтнуудын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл хэр вэ?

ЭРСДЭЛИЙН ЗУРАГЛАЛЫН ЖИШЭЭ

Тохиолдох магадлал

Маш олон (5)				① ⑦	
Их (4)	⑥		④		
Дунд (3)				③	
Бага (2)	⑤			②	
Маш цөөн (1)					
	Маш бага (1)	Бага (2)	Дунд (3)	Их (4)	Маш их (5)

Сөрөг үр дагавар

- ① Худалдан авах ажиллагааны зохин байгуулалт
- ② Албаны мэдээллийг зүй бусаар ашиглах
- ③ Төсвийн зарцуулалтын талаарх мэдээлэл ил тод бус
- ④ Хүний нөөцийн сонгон шалгаруулалт нээлттэй бус
- ⑤ Байгууллагын дотоод соёл хангалтгүй
- ⑥ Үйл ажиллагааны талаар мэдээлэл ил тод бус
- ⑦ Гомдол мэдээллийн нууцлалыг хангах байдал хангалгүй

## ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАСНЫ ЗАГВАР

(Шинжээчдийн багаар хүснэгтийн 5-6 дугаар баганыг 1-5-ийн хооронд үнэлүүлнэ, 5 бол сөрөг нөлөө их, тохиолдох магадлал их гэж үзнэ)

Байгууллагын нэр:				Огноо:	
Д/д	Эрсдэлийн нэр	Нөхцөл байдал	Үр дагавар	Сөрөг нөлөө	Тохиолдох магадлал
1	2	3	4	5	6
Жишээ нь					
Д/д	Худалдан авах ажиллагааны зохин байгуулалт	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг ил тод байршуулаагүй	Худалдан авах ажиллагаанд ил тод тэгш өрсөлдөх боломж бүрдээгүй	4	5
1.					
2.					
3.					
4.					
5.					
6.					
7.					
8.					
9.					
10.					

**Хавсралт 4.**

**ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР**

Д/д	Зөвлөмж буюу хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хариуцан хэрэгжүүлэх нэгж, ажилтан	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
6.				
7.				
8.				
9.				
10.				

1. Regional Anti-Corruption Initiative (RAI). 2015. *Corruption Risk Assessment in Public Institutions in South East Europe: Comparative Research and Methodology* [http://rai-see.org/wp-content/uploads/2015/10/CRA\\_in\\_public\\_ins\\_in\\_SEE-WEB\\_final.pdf](http://rai-see.org/wp-content/uploads/2015/10/CRA_in_public_ins_in_SEE-WEB_final.pdf)
2. World Customs Organization, 2012. *Revised Integrity Development Guide* [http://www.wcoomd.org/en/topics/integrity/-/media/B89997B68D6A4E34AE9571979EADA39F\\_as\\_hx](http://www.wcoomd.org/en/topics/integrity/-/media/B89997B68D6A4E34AE9571979EADA39F_as_hx)
3. World Customs Organization, 2015. *Guide to corruption risk mapping* [http://www.wcoomd.org/-/media/wco/public/global/pdf/about-us/legal-instruments/declarations/risk\\_mapping\\_guide\\_june\\_2015.pdf?la=en](http://www.wcoomd.org/-/media/wco/public/global/pdf/about-us/legal-instruments/declarations/risk_mapping_guide_june_2015.pdf?la=en)
4. UNDP and Global Organisation of Parliamentarians Against Corruption. 2013. *Anti-Corruption Self-Assessment Tool for Parliamentarians* <http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/democratic-governance/anti-corruption/anti-corruption-self-assessment-tool-for-parliamentarians.html>
5. Council of Europe. 2010. *Project against Corruption in Albania (PACA)–Corruption Risk Assessment Methodology Guide* [http://www.coe.int/t/dghl/cooperation/economiccrime/corruption/projects/Albania/Technical%20Papers/PACA\\_TP%202%202011-Risk%20Assessment%20Methodology.pdf](http://www.coe.int/t/dghl/cooperation/economiccrime/corruption/projects/Albania/Technical%20Papers/PACA_TP%202%202011-Risk%20Assessment%20Methodology.pdf)
6. Macedonia, Regional Anti-Corruption Initiative and Austrian Development Agency. 2016. *Setting up the Institutional and Operational Framework of Corruption Risk Assessment in Macedonia: Practical Suggestions and Reflections* <http://rai-see.org/wp-content/uploads/2015/05/RAI-Report-Setting-up-CRA-framework-in-Macedonia.pdf>
7. Government of the Republic of Moldova. 2008. *Methodology of Corruption Risk Assessment in Public Institutions* [http://www.coe.int/t/dghl/cooperation/economiccrime/moneylaundering/projects/molico/AC/Output\\_1.6/912%20MOLICO%20Nat%20%20Legisl%20\\_methodology%20of%20corruption%20risk%20assessment.pdf](http://www.coe.int/t/dghl/cooperation/economiccrime/moneylaundering/projects/molico/AC/Output_1.6/912%20MOLICO%20Nat%20%20Legisl%20_methodology%20of%20corruption%20risk%20assessment.pdf)
8. Montenegro Directorate for Anticorruption Initiative, UNDP and Delegation of the European Union in Montenegro. 2011. *Corruption Risk Assessment in Special Risk Areas* [http://www.me.undp.org/content/montenegro/en/home/library/democratic\\_governance/Corruption.html](http://www.me.undp.org/content/montenegro/en/home/library/democratic_governance/Corruption.html)
9. UNDP. 2015. *Users Guide to Measuring Corruption and Anti-corruption*, UNDP <http://www.undp.org/content/undp/en/home/librarypage/democratic-governance/anti-corruption/user-s-guide---measuring-corruption-and-anticorruption.html>
10. Martini, M. 2012. *Overview of Integrity Assessment Tools*, U4 Expert Answer [http://www.transparency.org/files/content/corruptionqas/340\\_Overview\\_of\\_integrity\\_assessment\\_tools.pdf](http://www.transparency.org/files/content/corruptionqas/340_Overview_of_integrity_assessment_tools.pdf)
11. Andy McDevitt, 2016, *Corruption self-assessment tools for the public sector*, U4 Expert Answer <http://www.u4.no/publications/corruption-self-assessment-tools-for-the-public-sector/>
12. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН 2013 ОНЫ 12 ДУГААР САРЫН 03-НЫ ӨДРИЙН А/248 ДУГААР ТУШААЛЫН ХАВСРАЛТ, 2013. *Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал* <http://police.gov.mn/a/421>
13. АЗИЙН САН, 2018. *Улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, авлигын эрсдэлийн үнэлгээ судалгааны тайлан*
14. ХАРААТ БУС СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН, АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР, НҮБ-ИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР, 2016. *Монголын уул уурхайн салбарын авлигын эрсдэлийн үнэлгээний тайлан* [https://www.iaac.mn/files/4347ff67-be17-4239-a929-bc5ebe4386c8/Corruption\\_risk\\_assessment\\_Mining\\_Mon.pdf](https://www.iaac.mn/files/4347ff67-be17-4239-a929-bc5ebe4386c8/Corruption_risk_assessment_Mining_Mon.pdf)